



Суурилах эх зохиол:
Альфонс Додэ
"Сүүлчийн хичээл"
өгүүллэг

Хичээлийн зорилго

- Зохиолыг мэдэрч ойлгож унших
- Зохиолын талаарх сэтгэгдэл мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэх
- Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлж, нийгэм, соёлын олон янз байдлыг ойлгож, дүгнэлт гаргах
- Зохиолын гадаад ба дотоод орчныг тодруулж, дүрд хэрхэн нөлөөж байгааг тодорхойлох
- Зохиолын дүр дүрслэл, найруулгыг шинжлэх

Зохиогчийн товч намтар




Францын зохиолч Альфонс Доде 1840 оны 5-р сарын 13-ны өдөр Францын Наймес хотод төрсөн. Залуу наснаасаа уран зохиол сонирхон, нийгмийн амьдралын эрээн бараан, шударга ариун үзэл, эх оронч сэтгэлгийг илэрхийлэн бичсэн бүтээлүүдээрээ францын болон дэлхий дахины уран зохиолын сан хөмрөгт нэмэр хандив оруулсан билээ. А.Доде олон жил багшилсан бөгөөд сургуулийн амьдралд өнгөрүүлсэн он жилүүдээ хожим зохиол бүтээлдээ тусгасан байдаг. “Сүүлчийн хичээл” өгүүллэг нь түүний амьдралтай салшгүй холбоотой юм. Тэрээр Прованс нутгийн тухай (1869 онд) бичсэн «Миний тээрмийн захиа» өгүүллэгийн түүврээрээ авьяаслаг зохиолч болохоо харуулан нэрд гарч эхэлжээ. Түүний томоохон бүтээлүүд бол «Бяцхан хүүхэд» (1868) роман, «Тарасконы Тартарены ер бусын адал явдал» (1872), «Тартарен Альпад» (1885), «Тараскон боомт» (1890) гурамсан зохиол зэрэг юм.

Түүхийн сургамжит домог:

MT 4-р зууны үед өмнө зүгт нүүдэллэн одоогийн Өвөр Монголын нутагт төр засаг байгуулан суусан Сяньбичууд харийн соёл иргэншилд автан мөхсөн түүхтэй. Сяньбичуудын байгуулсан Да Вэй хэмээх хятад нэртэй улсын хаан нь эх хэл бичгээ хэрэглэхийг зогсоож, гагцхүү хятад хэлийг хэрэглэхийг ард түмэндээ зарлигдсан аж. Гэвч энэ нь ард олны дунд амар бүтэхгүйг ойлгоод, эхлээд хааны ордонд төр улсын албанд эх хэл бичгээ хэрэглэхийг хориглож, гэтэл өвгөн настай түшмэд ноёд нь энэ зарлигт “тээг саад” болсон тул ордны доторх 30 - аас доош насны түшмэд албатууд төрийн ажил үйлийг гүйцэтгэхдээ зөвхөн хятад хэлбичиг хэрэглэх заавар гарган мөрдүүлсэн гэдэг. Мөхөх улс, сөнөх үндэстэн чухам тийм л хувь заяанд хүрдэг буй заа...

Я.Ганбаатар “ Утга зохиолын тухай яриа “ УБ 2010 он 238-р тал



Франц-Пруссын дайн 1870 - 1871 он хүртэл үргэлжилсэн III Наполеоны удирдлага дор байсан Францын Хоёрдугаар эзэнт гүрэн, Прусси ба түүний холбоотнууд болох Хойд Германы Холбоо ба Баден, Бавари, Вюртембергийн вант улсуудын хоорондох дайны мөргөлдөөн байв.

Зохиолд дарангуйлагчид газар нутгийг эзлээд зогсохгүй төрөлх франц хэлийг халж Францын Эльзас, Лотарингия дүүргийн сургуулиудад франц хэлний оронд герман хэл заах шийдвэр ирдэг. Ийм хүнд цаг үед франц хэлний багш Амель шавь нартаа франц хэлний сүүлчийн хичээлээ хүндэтгэлтэйгээр, гуниг харуусалтайгаар зааж, эх хэлээ хайрлан хамгаалж, мартаггүй байхыг зөвлөж байгаа, түүний хичээлд хүндэтгэл үзүүлэн тосгоны ахмадууд сүүлийн удаа оролцож, эх хэлээ алдаж, хамгаалж чадаагүйгээ ойлгож харамсдаг.

Түүнчлэн аливаа улс үндэстэнд эх хэл хэчнээн чухал болохыг сануулсан зохиол юм.

Зохиолын талаарх сэтгэгдэл мэдрэмж
үзэл бодлоо илэрхийлье

Сурах бичих 48- 51-р хуудас
А.Доде “ Сүүлчийн хичээл “
өгүүллэгийг унших

Зохиолыг уншаад юу бодогдов? Ямар сэтгэгдэл төрөв?



- Тэр өдөр хүү хичээлдээ оройтож очсоны учир юу вэ? Яагаад зугтаж, өдрийг гадаа өнгөрөөх талаар бодож байсан юм бол?
- Зарлалын самбарт сүүлийн үед ямар төрлийн мэдээ тавигддаг болсон бэ?
- Төмөрчин Вахтер хүүд яагаад яарсан яараагүй адилхан гэж хэлсэн бэ?



- Сүүлчийн өдөр хүүг Амель багшийн гайхшруулсан зүйл юу байв?
- Амель багшийн “Өнөөдөр франц хэлний сүүлчийн хичээл” гэж хэлснийг хүү хэрхэн хүлээж авав?
- Амель багш болон сургуулийн талаарх хүүгийн бодол хэрхэн өөрчлөгдсөн бэ?
- Ямар нөхцөл байдалд сүүлчийн хичээл оров? Эндээс юу мэдрэв?



- Тосгоны ахмадууд яагаад сүүлчийн хичээлд суув?
- Багш хүүгээр юу хэлүүлэхийг хүссэн бэ? Тэр хариулж чадсан уу?
- Амель багш яагаад өөрийгөө буруутгав?
- Амель багш франц хэлний талаар шавь нартаа хандаж юу гэж хэлсэн бэ?
- Зохиолд төрөлх хэлээ хайрлах, хамгаалах, эх хэл хэчнээн үнэтэй болохыг гэнэт ухаарсан ухаарал юуг харуулж байна вэ?
- Амель багш самбарт юу гэж бичсэн бэ?
- “Хэрэв чи франц хэлний сүүлчийн хичээлд суусан бол чамд ямар санагдах байсан бэ?”

Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлж, нийгэм, соёлын олон янз байдлыг ойлгож, дүгнэлт гаргаарай.



Бичвэр дотор үзүүлсэн орон цаг болоод нөхцөл байдлыг хам сэдэв гэнэ. Бид хам сэдвийн тусламжтайгаар янз бүрийн цаг үеийн соёлт нийгмийн талаар танин мэдэхээс гадна түүхэн, улс төрийн, нийгмийн, соёлын, шинжлэх ухааны талаар мэдэж авдаг.

- Зохиолд өгүүлэгдэж байгаа нийгэм цаг үеийн байдал ямар байв?
- Зохиолд туссан үнэт зүйл нь юу вэ?
- Зохиолд ямар ямар хам сэдэв голлон зонхилсон байна вэ?
- Амель багшийн төрх байдал, бодол, үг ярианаас ямар үзэл бодолтой хүн болохыг жишээгээр баталж дүгнэлт гаргаарай.

Зохиолын гадаад ба дотоод орчныг тодруулж, дүрд хэрхэн нөлөөж байгааг тодорхойлъё.

1. Зохиолын гадаад орчин

2. Зохиолын дотоод орчин

3. Дүрд хэрхэн нөлөөлж байна вэ?

Гадаад орчин

Үйл явдал ямар
орчинд өрнөв?

- Уйтгар, харуусал, гунигтай орчинд өрнөсөн.
- Айдастай орчинд өрнөсөн
- Урьд өмнө төсөөлж байгаагүй орчинд


Үйл явдал хаана
өрнөв?

- Эльзасын сургуульд



Жишээ нь:

- Ойн захын хөөндэйн жиргэх дуу үйлт нэрийн дүрмээс илүү сонирхлыг нь татаж байгаа боловч түүнийг орхиод сургуулт руу гүйж байгаагаас
- Франц хэлний сүүлчийн хичээл, саарын мөсөн дээр гулгах , шувууны үүр эрж хичээлээ тасалж байсан гэсэн харууслаас
- Дахиад багштайгаа тааралдахгүй гэж бодоход шугамаар цохиж байсан нь мартагдсан гэж бодож байгаагаас



- Үг яриа, үйлдэл , бодлоос нь харахад өсвөр насны хүү дүрслэгддэг.

	Ямар орчин нөхцөл, байдал дүрслэгдсэн бэ?	Хүүгийн зан чанар, үйл хэргийн өөрчлөлтийг бичээрэй.
Эхлэл хэсэгт	- Цэв цэлмэг, аагим халуун өдөр - Ринерийн нугад болон ойн захад хөөндэйн жиргэх дуу сонсогдоно.	Байгалийн сайхан хүүгийг сэтгэлийг татаж байсан ч хүү сургууь руугаа гүйсэн .
Гол хэсэгт Төгсгөл хэсэгт	- Бүтэн сайн өдрийн өглөө шиг нам гүм байдал - Ер бишийн баяр ёслолын байдал - Франц хэлний сүүлчийн хичээл	- Минчийтлээ улайж, дагжин чичирсэн - Хүүгийн гайхширал - Сүүлчийн хичээл гэдгийг сонсоод цочирдож буй байдал - Франц хэл үзэхгүйгээр цаашид амьдрах уу? - Цагийг дэмийн өнгөрөөж байсандаа гэсэн хармсал - Хэлний зүй, түүхийн ном 2 оосоо салах хагацах нь хэцүү байв. - Дахиад багштайгаа тааралдахгүй гэж бодоход шугамаар црхиж шийтгэдэг байсныг нь мартав . - Хэлний зүйн хичээлийг жигтэйхэн сайн ойлгов. - Багшийн тайлбар амархан санагдав. - Хичээнгүйлэн бичив. - Хаузерийг өрөвдөв.

	Ямар орчин нөхцөл, байдал дүрслэгдсэн бэ?	Хүүгийн зан чанар, үйл хэргийн өөрчлөлтийг бичээрэй.
Төгсгөл хэсэг	40 жилийн амьдарсан газраа орхиод явахад Амель багшид маш хэцүү байгаа байдал - Хичээлээ дуустал заахаар зориглосон багшийн хичээл зүтгэл	Өвгөн багшийнхаа талаар элдвийг бодож, хайрлаж, өрөвдөж, хүндэлж байгаа хүүгийн сэтгэлийн олон өнгө аяс



- “Би баатрын хоцорч байх үеийн харилцаа.....
- “Герман хэл заах шийдвэр Берлинээс ирсэн. Шинэ багш маргааш ирнэ” гэж хэлэх үеийн нөхцөл байдал дахь харилцаа.....
- “Би” баатрын багшийн асуултад хариулах үеийн харилцаа.....

Багш сурагчдын харилцааны уур амьсгалыг хэрхэн мэдэрч байгаагаа жишээ баримттайгаар хариулан бичээрэй.

Гадаад ,дотоод орчин дүрд хэрхэн нөлөөлж байна вэ?

Дотоод орчин:

Зохиолын үйл явдал өрнөх, дүрүүдийн амьдрах тэр цаг үеийн нөхцөл байдал болон дүрүүдийн хоорондын харилцааны уур амьсгалыг тодруулсан байдлыг дотоод орчин гэдэг . Дүрүүдийн хоорондын таатай, таагүй, хүйтэн хөндий, эсвэл дулаан сайхан харилцааны уур амьсгал уншигчдад хэрхэн мэдрэгдэж байгааг илэрхийлэх нь чухал.

Хүү

Төмөрчин Вахтер
Амель багш
Хаузер
Тосгоны хөгшчүүд

Харилцааны
уур амьсгал,
дүрүүдийн
сэтгэл санааны
байдал ямар
байв?



- Зохиолын эхэнд хүү ямар байв?
- Зохиолын төгсгөлд яаж өөрчлөгдөв?
- Тухайн явдлаас хүү юуг ухаарав? Хичээлийн эхэнд буй “Түүхийн сургамжит домог” – ийн утга санааг дахин эргэцүүлэн бодоорой хүүхдүүд ээ?

Зохиолын дүр дүрслэл, найруулгыг шинжлэх



- “Франц мандтугай” гэж самбарт бичиж байгаа Амель багшийн, биеийн болон сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлэхдээ ямар үг хэллэгийг зохиолч сонгож, утга санааг тодруулсан бэ?

Найз нөхөд минь гэж хэлснээ, найз нөхөд минь, би ...би гэсээр юм хэлж чадсангүй. Тэгснээ самбар луу эргэн, цэрд авч, байдаг хүчээ шавхан, том үсгээр “Франц мандтугай” гэж бичив. Тэгээд толгойгоо хананд наан, хөдлөхгүй зогсож, юу ч хэлэлгүй гараараа: - Одоо дууссан... явцгаа.. гэж дохиж билээ.

- Амель багшийн эх хэлээ, эх орноо гэсэн сэтгэлтэйг харуулахдаа зохиолч ямар үг сонгон хэрэглэсэн бэ? Эш татан бичээрэй.

- “Энэ тагтаануудыг бас германаар ярь гэж албадах байх даа “гэж бодож байгаа би баатрын бодлоос юуг мэдэрч байна вэ?

- Франц, Эльзас, Франц, Эльзас гэж их л эвтэйхэн бичжээ. Үүнийгээ ширээ бүрт хатгасан нь яг л дарцаг хэлхчихсэн юм шиг байлаа. гэсэн хэсгийг уран сайхныг мэдэрч дахин уншаарай. Яагаад “дарцаг хэлхчихсэн юм шиг “ бичсэн бэ? Юуг юутай адилтгасан бэ?

?

Анхаарал тавьсанд
баярлалаа .